



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

### Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.8, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Санлавмэд” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн эрхлэхийг “Санлавмэд” ХХК /Л.Оюун/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт, тавьж олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН